MONGOLIAN STOCK EXCHANGE

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 20 өдөр          Дугаар А/17          Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг
сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Нэйшнл секюритис ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Нэйшнл секюритис ҮЦК" ХХК /С.Хатанбаатар /-д анхааруулсугай.

3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ          Х.АЛТАЙ

0 0033